



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/321

Чингис хот

Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуулийн хугацаанд төлөөгүй, хайгуулын үйл ажиллагааны тайлан гүйцэтгэлийг зөвшөөрсөн хугацаанд ирүүлээгүй “Цээкүү” ХХК-ийн Цэнхэрмандал сумын нутаг дахь Хужхан нэртэй 82.62 га талбай бүхий XV-23000018 дугаартай, “Эмагима” ХХК-ийн Цэнхэрмандал сумын нутаг дахь Уст нэртэй 84.09 га талбай бүхий XV-23000003 дугаартай, Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Баянхутаг сумын нутагт Сондуулт нэртэй 30.1 га талбай бүхий XV-23000026 дугаартай Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг цуцалсугай.

Хоёр. Тусгай зөвшөөрөл цуцалсан тухай шийдвэрийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Цэнхэрмандал, Баянхутаг сумдын Засаг дарга нарт тус тус мэдэгдэж, Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

Гурав. Хайгуулын ажил хийгдсэн талбайд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан аж ахуйн нэгж компаниар нөхөн сэргээлт хийлгүүлж, байгаль орчны хохирлыг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг Цэнхэрмандал сумын Засаг дарга (С.Золжаргал), Баянхутаг сумын Засаг дарга (Б.Амгаланбат) нарт даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/72, А/177, 2017 оны А/216 дугаартай Тусгай зөвшөөрөл олгох тухай захирамжуудыг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011700